



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 307

Улаанбаатар хот

Төсвийн тодотгосон хуваарь батлах тухай

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. "Монгол Улсын 2015 оны төсвийн орлогын сар, улирлын хуваарь"-ийг 1 дүгээр хавсралтаар, "Монгол Улсын 2015 оны төсвийн зарлага, санхүүжилтийн сар, улирлын хуваарь"-ийг 2 дугаар хавсралтаар, "Монгол Улсын 2015 оны төсвийн хөтөлбөр, арга хэмжээний сар, улирлын хуваарь"-ийг 3 дугаар хавсралтаар, "Улсын төсвөөс 2015 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг"-ийн хуваарийг 4 дүгээр хавсралтаар, "Орон нутгийн төсвөөс 2015 оны төсвийн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлэх орлогын сар, улирлын хуваарь"-ийг 5 дугаар хавсралтаар, "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2015 онд аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарь"-ийг 6 дугаар хавсралтаар, "Улсын төсвөөс 2015 оны төсвийн жилд орон нутагт олгох тусгай зориулалтын шилжүүлгийн сар, улирлын хуваарь"-ийг 7 дугаар хавсралтаар, "Улсын төсвийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн сар, улирлын хуваарь"-ийг 8 дугаар хавсралтаар, "Хөгжлийн банкны эх үүсвэрээр эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр 2015 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн сар, улирлын хуваарь"-ийг 9 дүгээр хавсралтаар, "Эрчим хүч, дулааны алдагдлын 2015 оны татаасны хуваарь"-ийг 10 дугаар хавсралтаар, "Монгол Улсын 2015 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн сар, улирлын хуваарь"-ийг 11 дүгээр хавсралтаар, "Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн сар, улирлын хуваарь"-ийг 12 дугаар хавсралтаар, "Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн сар, улирлын хуваарь"-ийг 13 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу олгохыг Төрийн сангийн газар /С.Наранцогт/-т зөвшөөрсүгэй.

САЙД



БОЛОР

